

## МОНГОЛ УЛС ДАХЬ ШАШНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

*Ж.Алтайбаатар (Ph.D)*

*Шашин судлаачдын монголын нийгэмлэг,  
гүйцэтгэх захирал*

**Түлхүүр үгс:** *Шашны байгууллага, сүм хийд, төр - сүм хийдийн харилцаа, шашны байгууллагын бүртгэл, буддын шашин, христийн шашин, исламын шашин*

**Товч утга:** *1990-ээд оноос хойш Монгол Улс дахь шашны болоод иргэдийн сүсэг бишрэлийн төлөв байдал, хандлагын талаар социологийн судалгаа цөөнгүй хийгдсэн боловч шашны байгууллагуудын төрөл хэлбэр, байриил, нягтрал, тусгай зөвшөөрлийн тухай нэгдсэн тоо, бүртгэл бүхий мэдээ, баримт өнөөг хүртэл дутмаг байна. Өөр хоорондоо ялгаатай чиг үүрэг бүхий төрийн захиргааны хэд хэдэн байгууллага шашны байгууллагуудын бүртгэл, мэдээллийг бүрдүүлж байгаа бөгөөд эдгээр нь өөр хоорондоо зөрүүтэй байх нь нийтлэг байна.*

*Энэхүү илтгэлд шашны байгууллагуудын талаарх статистикийн болон бүртгэлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар Монгол Улс дахь шашны байгууллагын төрөл, хэлбэр, тархалтын дүр зургийг тодруулахыг зорив.*

\* \* \* \* \*

Шашны зохион байгуулалтын талыг илэрхийлсэн нэг чухал элемент бол шашны байгууллага бөгөөд шашны итгэл үнэмшил, шашны ухамсарын тодорхой түвшин дэх хүмүүсийн өвөрмөц нэгдлийг илэрхийлдэг ойлголт билээ.

Шашны тахилга шүтлэгийн болон тахилга шүтлэгийн бус зохион байгуулалттай үйл ажиллагаа нь шашны янз бүрийн байгууллагуудаар дамжин илэрдэг. Энэ утгаараа шашны байгууллага нь шашны оршин тогтнохын үндэс нь болж, сүсэгтний сүсэг бишрэлийг гүнзгийрүүлэх, хүн амыг шашны үйл хэрэгт хөтлөн оруулагч нэг чухал хүч болж байдаг.

Шашны байгууллага нь шашны сүсэг бишрэлийн төлөв байдал, цар хүрээ, нийгмийн нөхцлөөс хамаарч улс үндэстэн бүрт харилцан адил бус хугацаанд бүрэлдэн тогтож иржээ. Тотемизм, анимизм, фетишизм зэрэг шашны эртний хэлбэрүүдэд нэгдмэл зохион байгуулалт бүхий шашны байгууллага байгаагүй боловч овог, отгийн ахлагч, оюун санааны удирдагчид болох бөө, удган, тайлгач нарын удирдлага дор сүсэг бишрэлийн зан үйлийг гүйцэтгэж байсан нь түүхэн эх сурвалж, археологийн олдворуудаас тодорхой харагддаг.

### **Шашны байгууллагын хэлбэрүүд**

Шашны зохион байгуулалтын хэлбэрийг ангилж ажлын үндсийг Макс Вебер болон Эрнст Трельч нар анх тавьсан бөгөөд **сүм хийд** ба **сект** гэсэн үндсэн хоёр хэлбэрт хуваан авч үзжээ (Troeltsch, 1931, хууд. 993). Энэ ангилал олон арван жил шашины судалгааны удирдамж болж ирсэн ба хожим Ховард Бейкер, Милтон Юнгер нарын судлаачид Вебер, Трельч нарын ангиллыг цааш нь хөгжүүлж деноминаци болон калт гэсэн шашны байгууллагын өөр хоёр хэлбэрийг тодорхойлжээ (Yinger, 1970, p. 279).

1. Сүм хийд ба экклеси
2. Деноминаци (өргөтгөл нийгэмлэг)
3. Сект (ердийн бүлэглэл)
4. Тахин шүтлэг буюу культ (явцуу бүлэглэл) эдгээр болно<sup>1</sup>.

**Сүм хийд** бол шашны байгууллагын үндсэн хэв маяг бөгөөд нийтээр зөвшөөрөгдсөн, сайтар бэхжин тогтсон, шашны тахил шүтлэгийн үйлийг мэргэжлийн түвшинд гүйцэтгэгч гэж хэлж болох албан ёсны шашны байгууллага юм. Сүм хийд нь тухайн улсынхаа нийгмийн бүхий л салбарт нэр нөлөөтэй болж чадсан, байгууллагын хувьд төлөвшил, зохион байгуулалтын өндөр түвшинд хүрсэн шашны байгууллагын хэлбэр юм.

Сүм хийд, үзэл сургаалын хувьд төлөвшсөн, удирдлагын хувьд мэргэшсэн байдаг бөгөөд бүр эртнээс уламжлан мөрдөж, үйлдэж ирсэн зан үйлийн нэгдмэл тогтолцоо, литург бүхий байдаг.

Сүм хийд нь олонхи тохиолдолд уламжлалт шашных байх бөгөөд үүний сонгодог жишээ нь дэлхийн гэх тодотголтой ромын католик, грек, оросын үнэн алдартан, буддын шашны чиглэлүүд, протестант болон англикан сүмүүдийг жишээ болгож болох юм.

Сүм хийдийн үйл ажиллагааны гол онцлог нь тогтсон зан үйл, цэгцтэй сургаал, шашны тэмдэглэлт арга хэмжээнүүдийг нийгмийн бүхий л хүрээг хамруулан зохион байгуулах явдал байх бөгөөд нийгмийн бусад институтуудтай нарийн нягт хамтран ажиллах нь элбэг тохиолддог.

Монгол орны хувьд Буддын шашин, исламын шашны сүм хийдүүд, протестант шашны болон шинэ урсгал, хөдөлгөөнүүд шашин номын үйл ажиллагаагаа идэвхитэй явуулдаг бөгөөд, христийн шашны католик, үнэн алдартны сүм хийдүүд боловсрол, хүмүүнлэгийн үйл ажиллагаа болон өөрийн шашныг шүтэгч цөөн тооны сүсэгтний сүсэг бишрэлийн эрэлт хэрэгцээг хангах зорилгоор төдий л идэвхитэй бус, зан үйлийн шинжтэй үйл ажиллагааг явуулдаг.

Сүм хийд нь нийгмийн оюун санааны ертөнцөд тодорхой хэмжээний үүргүүдийг гүйцэтгэж ирсэн бөгөөд нийгмийн гишүүдийн оюун санаа болон сэтгэл зүйд маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Сүм хийд нь дараах хэд хэдэн үүргийг гүйцэтгэдэг:

- Сүсэгтнийг шашны сургаалаар дамжуулан хүмүүжүүлэх буюу үүгээрээ нийгмийн ёс суртахууны тодорхой хэм хэмжээг бий болгох
- Сүсэгтний оюуны, сүсэг бишрэлийн хэрэгцээг хангах (тайвшруулах, тайтгаруулах, сэтгэл санааны дэм өгөх гэх мэт)
- Тухайн улс түмний соёлын тодорхой уламжлалыг өвлөн авч хойч үед дамжуулан хүргэх
- Шашны талаарх нэгдмэл бодлогыг тодорхойлох төрийн бодлогод нөлөөлөх зэрэг болно.

Сүм хийдийн үйл ажиллагааны үндсэн зорилгыг цэвэр оюун санаа буюу шашны үйл хэрэг ба нийгмийн байр суурийн төлөөх гэсэн 2 хэсэгт хуваан үзэж болно.

Шашны номлол сургаалийг хөгжүүлэх, дэлгэрүүлэх, өвлүүлэн үлдээх, шүтэн бишрэгчдийнхээ оюун санааны амьдралд тодорхой хэмжээгээр нөлөөлөн, тэдэнд дэм өгөх,

<sup>1</sup> Смейлзер, Н. Социологи. Улаанбаатар, 2001. хуудас 438-439

бие хүнд шашны номлол, ёс уламжлал, үзэл баримтлалын агуулга бүхий ёс суртахууны хэм хэмжээг төлөвшүүлэх зэрэг нь сүм хийдийн оюун санаа, шашны үйл хэргийн зорилго мөн.

Харин нийгэмд өөрийн байгууллагын байр суурийг эдийн засаг болон нэр хүндийн талаас бэхжүүлэх, нийгмийн сэтгэл зүй, олон нийтийн санаа бодолд шашны үзэл санааны үзүүлэх нөлөөг дээшлүүлэх, сүсэгтнийхээ хүрээг тэлэх, шашны тогтоосон ёс дэг, ёслолыг ном журмын дагуу гүйцэтгэж, үүгээрээ дамжуулан сүсэгтний бүлгийн бүтцийг батжуулах зэрэг нь сүм хийдийн нийгмийн байр суурийг бэхжүүлэх зорилгод нийцэх юм.

Сүм хийд, түүний тахил шүтээний байгууламжууд нь хүн амд сүсэг бишрэлээр гүнзгий нөлөөлж, тэдний оюун санааны хэрэгцээг хангах чухал төв болж байдаг.

АНУ-ын Балл Стейт Их сургуулийн профессор, судлаач Роналд Л.Жонстоун сүм хийдийн дараах долоон онцлог шинжийг тодорхойлсон байна. Үүнд:

1. Нийгмийн бүх гишүүдийг өөртөө хамаатуулсан нэгдмэл байдлыг хадгалж, “иргэний харьяалал” хэмээх ойлголтыг “гишүүнчлэл” гэсэн ойлголттой адилтган авч үзэхийг оролддог;
2. Нэг шашны ноёрхолыг дэмжин хөхиүлж, шашин хоорондын өрсөлдөөнийг үгүйсгэдэг;
3. Төр болон шашны бус байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, харилцаагаа бэхжүүлж байдаг;
4. Хөдөлмөр хуваарилалтын нарийн систем бүхий шатлан захирах зохион байгуулалттай;
5. Албан ёсны, өндөр мэргэшсэн, дадлага туршлага бүхий сахил хүртсэн санваартнууд бүтэн цагаар ажилладаг;
6. Хүүхдийг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх үйл явцын ачаар шинэ гишүүдийнх нь тоо аяндаа нэмэгдэж байдаг (удам дамжсан, гэр бүлийн шүтлэг);
7. Сүм хийдийн дотор хоорондоо ялгаа бүхий бүлгүүд (хувраг, эсвэл гэлэнмаа нарын орден) үүсэж бий болохыг зөвшөөрдөг.<sup>1</sup>

Сүм хийдийн боловсронгуй хэлбэр нь *эклеси* юм. Эклеси нь дээр дурдсан сүм хийдийн шинжүүдийг өөртөө агуулж нийгмийн гишүүдийг бүхэлд нь хамардаг боловч тухайн нийгэмд дангаар ноёрхогч ганц шашин байж чаддаггүй. Дани (Данийн сүм, Фарое арлын сүм), Финланд (Финландын сүм, Финнийн Ортодокс сүм), Грек (Грекийн сүм), Исланд (Исландын сүм), Норвеги (Норвегийн сүм), Их Британи (Английн англикан сүм, Шотландын сүм) зэрэг Европын орнуудын төрийн албан ёсны гэгдэх шашны байгууллагуудыг энэ хэлбэрт хамааруулан үзэж болно.

**Сект буюу бүлэглэл** нь шашны үндсэн урсгал, сүм хийдээс үзэл санаа, удирдлагын хувьд бие даан тусгаарласан зохион байгуулалтын нэг хэлбэр юм.

Уламжлалт шашны байгууллагын эсрэг сөрөн зогсож, тэдний үйл ажиллагааг шүүмжлэн, өөрсдийн шашны шинэ үзэл сургаал, баримтлалыг бий болгон, нийгмийн оюун санааны амьдралд нөлөөлөхийг оролдох үед энэ төрлийн шашны байгууллагууд үүсэн бий болдог. Шашны сектүүд нь ноёрхогч шашны үзэл санаа, баримтлалд шүүмжлэлтэй хандах бөгөөд нийгмийн амьдралд сөргөлдсөн байдалтай хандах тохиолдол

<sup>1</sup> Johnstone, R. Religion in Society: A Sociology of Religion. New Jersey, 2006. p. 148

бий. Тухайлбал боловсролын системд шүүмжлэлтэй хандах, эрүүл мэндийн үйлчилгээг эсэргүүцэх гэх мэт.

Сектийн гишүүд нь тооны хувьд цөөн, гишүүнчлэлийн байдал хатуу чанд, нарийн зохион байгуулалттай, үйл ажиллагааны хувьд өргөн дэлгэр бус, үзэл баримтлалын хувьд ноёрхогч шашны номлолтой сөргөлдөх тул гишүүд нь зарим талаараа нийгмээс тусгаарлагдсан, гадуурхагдсан шинжтэй байх нь бий.

Сект нь нийгэмд эерэг, сөрөг хоёр талтай. Эерэг тал нь нийгэмд ноёрхогч шашны хэт хуучинсаг үзэл санаа, номлол сургаал, зан үйлийн хэлбэрийг эсэргүүцэн няцаах замаар тухайн шашинд шинэчлэлийн элементийг бий болгох талтай. Мөн шинэ цаг үеийн нийгмийн хэрэгцээ шаардлага, ашиг сонирхолыг соргоогоор мэдэрч түүнийг олон нийтийн хүртээл болгохыг эрмэлзэж байдаг байна. Сөрөг тал нь, ихэнхи тохиолдолд сектүүд нийгэмтэйгээ зөрчилдөж уламжлалт тогтсон зан үйл, үзэл сургаалд шүүмжлэлтэй ханддаг. Үйл ажиллагаа нь нийгэмд олонхийн дэмжлэг авч чадаагүйгээс нийгэмд хориотой арга замаар өөрсдийн үйл ажиллагааг явуулахыг эрмэлздэг байна.

**Деноминаци** нь сүм хийд болон сектийн завсрын шинжтэй, аядаж намдсан сект бөгөөд идэвхтэй сөргөлдөгч бүлэг байхаа болиод нэлээд тогтвортой институт болон хувирсан байдаг. Сектүүд нь нэлээд хугацааны туршид тогтвортой, бүхэл байдлаа хадгалан оршин тогтнож чадвал деноминаци болж хүлээн зөвшөөрөгдөх нь гарцаагүй ажээ. Сүм хийдийн зүгээс их, бага хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн деноминациуд нь сүмүүдтэй зэрэгцэн оршиж, хамтран ажиллах тохиолдол байдаг байна.

Деноминацийн хувьд шүтэн бишрэгчдийнхээ тоо, цар хүрээгээр шашны бусад урсгалуудыг даван гарах эрмэлзлэл бүхий америк маягийн хэв шинжит шашны байгууллага гэж Смейлзер үзжээ<sup>1</sup>. Сектүүд нийгмийн харилцаанд сөргөлдсөн хандлагыг илэрхийлдэг бол деноминацууд нийгмийн бусад институтуудтэй идэвхтэй харилцаа холбоо тогтоож, зарим тохиолдолд төрийг дэмжсэн хандлагатай ажилладаг байна.

Деноминаци гол төлөв сүм хийд нийгэмд дангаар ноёрхогч байр сууриа алдах үед гарч ирдэг. Сүм хийд болон сект деноминаци болж хувирахдаа дараах шинж чанаруудыг өөртөө агуулах болдог. Үүнд:

1. Сүм хийдтэй төсөөтэй, сектээс ялгарах тал нь төр болоод шашны бус бусад байгууллагуудтай сайн харилцаатай байж, төрийн үйл ажиллагаанд нөлөөлөхийг оролддог;
2. Шашны олон ургальч үзэл санаанд хүлээцтэй хандаж нийгэм дэх бусад деноминацуудтай найрсаг харилцаатай зэрэгцэн оршдог;
3. Гишүүнчлэлээ нэмэгдүүлэхдээ удам дамжсан гишүүнчлэлд найдах боловч бусад шашнаас элсүүлэхэд идэвхи чармайлт гаргадаг;
4. Теологи, гүн ухааны маргаанд хүлээцтэй хандаж, сургаал, номлол ба зан үйлийн бага зэрэг өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх хандлага баримталдаг;
5. Сэтгэл хөдлөлөө бага илэрхийлсэн шашны зан үйл, хамтын мөргөл үйлддэг;
6. Деноминациас тавигдах шаардлагад нийцсэн, мэргэшсэн санваартныг сургаж, ажиллуулдаг;
7. Гишүүдийг денонимацийн үйл ажиллагаанд сектийг бодвол харьцангуй бага, сүм хийдийг бодвол илүү өргөн хүрээтэйгээр татан оролцуулдаг;

<sup>1</sup> Смейлзер, Н. Социологи. Улаанбаатар, 2001. хуудас 438

8. Нийгмийн дээд болон дунд давхаргаас гол төлөв шууд бус хамааралтай<sup>1</sup> Баптист, Методист, Лютеран, зэрэг христийн шашны ихэнхи пост-реформист урсгалууд энэ хэлбэрийн байгууллагаар дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг.

**Калгууд** нь зохион байгуулалтын хувьд илүү чөлөөтэй, сектийн адил тогтсон үнэт зүйл, тогтолцоог сөрөн зогсож, үгүйсгэх хандлагатай, уриалан зоригжуулагч нөлөө бүхий харизматик удирдагчийг тойрон хүрээлсэн сүсэгтнүүдийн бүлгийн хэлбэртэй орших ажээ. Гэхдээ сектээс илүү эрч хүчтэй үйл ажиллагаа, хатуу сөрөг байр суурь, тусгаарлагдмал байдлаар ялгардаг байна. Орчин үед энэ төрлийн шашны байгууллагыг шинэ шашны хөдөлгөөн гэх нэрийн дор судалж байна.

Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, стандартчлагдсан, тогтсон ягшмал номлолоос огт өөр, шинэ үзэл санаа, сүсэг бишрэл, зан үйл нь сүсэгтнүүдэд гүн гүнзгий сэтгэгдэл төрүүлдэг нь калтын нэг өвөрмөц онцлог бөгөөд шашны үндсэн урсгал, сүсэгтнүүдийн үндсэн хэсгээс холбоогоо тасалж, салан тусгаарлах замаар үүсэн бий болдог байна (Смейлзер.Н., 2017, хууд. 353).

Энэ төрлийн шашны байгууллагуудын дараах үндсэн шинжүүдийг агуулдаг байна. Үүнд:

1. Үүсэн бий болсон цаг хугацааны хувь шинэ, саяхан бий болсон;
2. Үзэл баримтлал, номлол сургаал нь төдийлөн бэхжээгүй, олон янзын эх үүсвэрээс бүрдсэн, синкретик буюу янз бүрийн сургаал номлолын “нийлмэл” шинжтэй;
3. Сүсэгтнүүдээ ятган үнэмшүүлэх, манипуляци хийх замаар элсүүлдэг;
4. Оршин буй нийгэмдээ шүүмжлэлтэй хандаж, нийгмээс тусгаарлах, эсвэл оршин буй нийгэмдээ гажууд гэж тооцогдохуй соёлыг сурталчилах, уламжлалт шашин соёл, үнэт зүйлст шүүмжлэлтэй хандах;
5. Тодорхой нэг хувь хүн, эсвэл бүлэг хүмүүсийн манлайлал, харизмын нөлөөнд оршдог<sup>2</sup>.

Сүүлийн жилүүдэд дэлхийн олон орнуудад шашны дээр дурдсан байгууллагын төрлүүдээс гадна **Сүсэг бишрэлд суурилсан олон нийтийн байгууллага (FBO-faith based organization), Шашны олон нийтийн байгууллага (RNGO – religious non-governmental organization)** гэсэн шинэ өвөрмөц төрлийн байгууллагууд бий болох боллоо. Эдгээр байгууллагууд нь шашны сүсэг бишрэлд суурилан, шашны ямар нэгэн үзэл сургаалийг байгууллагын үнэт зүйл, эрхэм зорилго болгон тодорхойлж олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг онцлогтой ажээ.

Шашны олон нийтийн байгууллага нь нэг болон хэд хэдэн шашны болоод оюун санааны уламжлал, үзэл номлол, сургаалд үндэслэн үйл ажиллагааны хэтийн зорилго, байгууллагын өвөрмөц шинж нь бүрэлдэн тогтсон, үндэсний болон бүс нутаг, олон улсын түвшинд нийгмийн сайн сайхныг бий болгох үзэл санаа бүхий ашгийн бус, чөлөөт, сайн дурын, хамтын удирдлагын байгууллага<sup>3</sup> юм. Эдгээр байгууллагууд нь:

1. Илт шашныг дэмжсэн, түүнийг сурталчилсан;

<sup>1</sup> Johnstone, R. Religion in Society: A Sociology of Religion. New Jersey, 2006. p. 151

<sup>2</sup> Алтайбаатар, Ж. Монгол Улс дахь шинэ шашны хөдөлгөөн: өнөөгийн байдал, хандлага. Улаанбаатар, 2019.

<sup>3</sup> Martens, K. Mission Impossible? Defining Nongovernmental Organizations. Voluntas 13 (4). 2002. pp. 271-285

2. Үйл ажиллагааны зорилго нь шашны зан үйл (хурал ном, мөргөл гэх мэт)-д чиглэх бус, шашны үзэл санаанд суурилан нийгэмд хандсан, идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг;
3. Гишүүнчлэл нь нээлттэй, сайн дурын шинжтэй;

Эмнэсти Интернэйшнл, Оксфам (OXFAM), Грийнпис (Greenpeace), Сока Гаккай Интернейшнл, Дэлхийн зөн, Мерси Кор, Дэлхийн еврейчүүдийн конгресс зэрэг даян дэлхийн энх тайван, тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчин, хүний эрх, засаглалын асуудлаар нэгдэн нягтарч, хамтран ажиллах санаачилга өрнүүлэн үр дүнд хүрч буй шашны олон нийтийн байгууллагын багагүй жишээг дурдаж болно.

Монголын нөхцөлд эдгээр байгууллагууд нь эрх зүйн орчноос хамаараад ТББ-ын хэлбэрээр л үйл ажиллагаагаа явуулах боломжтой байна.

### **Монгол Улс дахь шашны байгууллагууд**

Дээр дурдсан шашны байгууллагын хэлбэрүүдээс манай улсад хамгийн түгээмэл тархсан хэлбэр нь сүм хийд юм.

Шашны байгууллагыг Төр сүм хийдийн харилцааны тухай хуулийн 6 дугаар зүйлд "Сүсэгтэн олны шашин номын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдаж, шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлыг эрхлэн гүйцэтгэж буй албан ёсны зөвшөөрөл бүхий хийд, сүм, дацан, төв болон тэдгээрийн удирдах байгууллагыг шашны байгууллага гэнэ" гэж заасны дагуу шашны байгууллагын зорилго нь сүсэгтэн олонд шашин номыг номлох, шашны зан үйл, хурал ном, шашны боловсролын ажлыг эрхэлдэг чиг үүрэгтэй байгууллага байхаар зохицуулсан.

Өөрөөр хэлбэл дээрх шашны байгууллагын хэлбэрээс зөвхөн сүм хийдийг л зохицуулахаар туссан байдгаас бүртгэл, статистикийн мэдээлэлд деноминаци, сект, калт буюу шинэ шашны хөдөлгөөн, шашны олон нийтийн байгууллагуудын мэдээлэл хангалттай бус буюу бараг байхгүй байна.

Шашны байгууллагыг бүртгэж, зөвшөөрөл олгох үйл явц нь Төр сүм хийдийн харилцааны тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, эдгээр хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан нийслэл, аймгийн ИТХ-ын холбогдох журмуудаар зохицуулагддаг.

*Төр сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйл 9.1 дэх хэсэгт "Сүм хийд байгуулах тухай иргэдээс гаргасан өргөдлийг дүрмийн хамт аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хянан үзэж, зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ. Олгосон зөвшөөрлийг үндэслэн сүм хийдийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэнэ" гэж заасан.*

*НИТХ сүм хийд байгуулах хүсэлтийг хянан, зөвшөөрлийг олгодог. Олгосон зөвшөөрлийг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэхээр заасан бол Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар 7.1.1 дэх хэсэгт зааснаар нөхөрлөл, компани, хоршоо, төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, холбоо, сан, **шашны байгууллага**, хэвлэл мэдээллийн хэрэгслийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь салбар бүртгэх зохицуулалттай.*

**Зураг 1.** Улсын бүртгэл бүртгүүлэх, зөвшөөрөл авах, сунгуулах үйл явцын зураглал



Шашны байгууллагын бүртгэл, мэдээллийн асуудал хариуцдаг эрх бүхий төрийн захиргааны байгууллагууд өөр хоорондоо ялгаатай чиг үүргийн хүрээнд ажилладагтай холбоотойгоор шашны байгууллагуудын бүртгэлийн мэдээлэл болон статистик өөр хоорондоо зөрүүтэй байгааг судлаачид онцолдог.

2016 онд Хууль зүйн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн танилцуулгаас үзэхэд шашны байгууллагын талаарх бүртгэл, мэдээллийн сан бүхий цагдаа, тагнуул, статистик, улсын бүртгэлийн байгууллагуудын мэдээллүүд өөр хоорондоо ихээхэн ялгаатай байгаа нь харагдана.

**Хүснэгт 1. Шашны байгууллагуудын бүртгэл, статистикийн мэдээлэл**

Үндэсний статистикийн хороо (2016)	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар (2016)	Хууль зүй, дотоод хэргийн яам (2016)
<b>350 шашны байгууллага:</b>	<b>433 шашны байгууллага.</b>	<b>848 шашны байгууллага:</b>
Буддын 38.9% Христийн 52.3% Исламын 6.3% Бусад 2.6%		Буддын 34.6% Христийн 54.2% Исламын 5.1% Бусад 6 %

Ийм зөрүүтэй байгаагийн шалтгааныг дараах байдлаар тайлбарлаж болох юм. Үүнд:

1. Хууль зүйн яам болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын мэдээлэл нь холбогдох зөвшөөрөлд үндэслэн хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэсэн шашны байгууллагын тоонд түшиглэж байна.
2. Үндэсний статистикийн хорооноос гаргадаг тоон мэдээлэл нь аймаг нийслэлийн статистикийн хэлтэст тайлангаа ирүүлсэн шашны байгууллагын мэдээлэлд тулгуурлан гаргадаг.


Хэдийгээр ийм зөрөө, ялгаа байгаа ч бид Монгол Улс дахь шашны байгууллагын төрөл, хэлбэр, тархалтын байдлыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлсэн шашны болон төрийн бус байгууллагын мэдээлэл, Хууль зүйн яамны шалгалтын дүн, Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн тодруулахыг оролдлоо. Ингэхдээ, нэгд, тухайн

шашны байгууллага бүртгэл зөвшөөрөлтэй эсэх, хоёрт, тогтвортой үйл ажиллагаа явуулж буй эсэхэд анхаарал хандуулав.

2018 оны эхний байдлаар, бидний тооцоогоор Монгол Улсын хэмжээнд 812 шашны байгууллага байна. Эдгээр шашны байгууллагын 517 нь буюу 63.6% нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, өөрөөр хэлбэл ямар нэг зөрчилгүй шашны байгууллагууд байгаа юм. Харин үлдсэн 295 шашны байгууллага буюу 36.4% нь бүртгэл, зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа ажээ.


Шашны байгууллагыг төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

**Зураг 2. Шашны байгууллагууд, төрлөөр (2018)**



Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагуудын талаас илүү хувийг Христийн сүм, чуулган, цуглаан эзэлж байгаа бөгөөд энэ нь урсгал, чиглэлийн хувьд янз бүрийн төрөлд хуваагдаж байна. Бидний судалгаанд ашигласан мэдээллийн бүрэн бус байдлаас үүдээд урсгал бүрт хамаарах шашны байгууллагуудыг нэг бүрчлэн гаргах боломжгүй байна. Харин христийн шашинд хамаарах ямар төрлийн урсгал чиглэл манай улсад байгааг тойм байдлаар харуулбал дараах байдалтай байна.


**Зураг 3. Монгол Улс дахь христийн шашны урсгалууд**



Нөгөө талаар христийн шашны байгууллагуудын тоо хэмжээнээс үүдэн энэ төрлийн шашин шүтлэг манай улсад зонхилж байна гэсэн шууд дүгнэлтэд хүрч болохгүй юм. Сүсэгтний хувьд буддын шашин зонхилсон хэвээр байгааг шашин шүтлэгийн төлөв байдлын судалгааны үр дүн харуулж байна<sup>1</sup>.

<sup>1</sup> ШУАФХ. Монгол Улс дахь шашин шүтлэгийн төлөв байдлын судалгаа. Улаанбаатар: ШУА-ийн Философийн хүрээлэн, 2017.

**Зураг 4. Монгол Улс дахь сүсэгтнүүд**



Нийт шашны байгууллагуудын дотор бүртгэлгүй, зөвшөөрөлгүй байгууллагуудын тоогоор ч христийн шашны байгууллагууд давамгайл байдалтай байгаа юм. Зөвшөөрөлгүй байгууллагуудын 56.9% нь христийн шашны байгууллагууд байгаа бөгөөд зөвшөөрөлгүй буддын шашны сүм хийдүүд 33.2%-ийг эзэлж байгаа ажээ.

**Зураг 5. Бүртгэлтэй болон бүртгэлгүй шашны байгууллагууд**



Бүртгэлгүй, зөвшөөрөлгүй ажиллаж байгаа шашны байгууллагуудад дараах нийтлэг дутагдал ажиглагдаж байна. Тухайлбал:

- Дөнгөж үүсэн байгуулагдсан, эсвэл бүртгэл, зөвшөөрлөө авахаар хөөцөлдөж байгаа гэх тайлбартайгаар үйл ажиллагаа явуулж байгаа;
- Зөвшөөрлийн хугацаа дууссан ч хуулийн этгээдийн гэрчилгээтэй гэдэг үндэслэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа;
- Ямар нэгэн шашны байгууллагын салбар байгууллага гэсэн нэрийн дор ажиллаж, төв байгууллагад байгаа зөвшөөрөл, гэрчилгээтэй гэдэг тайлбартайгаар үйл ажиллагаа явуулж байгаа;

- Ямар нэгэн бүртгэл, зөвшөөрөл авалгүй ажиллаж байгаа зэрэг болно.


Хуулийн этгээдийн бүртгэл нь бидэнд өнгөрсөн хугацаанд хичнээн шашны байгууллага зөвшөөрөл авч бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгааг харуулж байгаа бол статистикийн мэдээлэл нь тухайн онд улсын хэмжээнд тогтвортой ажиллаж байгаа шашны байгууллагуудын мэдээллийг харуулдаг.

Үндэсний статистикийн хорооны даргын 2013 оны 12-р сарын 1/150 тоот тушаалаар баталсан СХ-1 маягтын дагуу шашны байгууллагын мэдээллийг цуглуулдаг. Уг маягтаар шашны байгууллагын хаяг, бүртгэлийн мэдээлэл, ажиллагчдын тоо, шашны сургууль, дацанд суралцагчид, төгсөгчдийн тоо, сайн дурын ажилтнуудын тоо, орлого, зардын мэдээллийг авч байна.

Мэдээллийг тухай шашны байгууллага 1, 4, 7, 10-р сарын 15-ны дотор аймаг, нийслэл (дүүрэг)-ийн статистикийн газар, хэлтэст маягт болон цахим шуудангаар ирүүлж, аймаг, нийслэл (дүүрэг)-ийн статистикийн газар, хэлтэс 1, 4, 7, 10-р сарын 21-нд Үндэсний статистикийн хороонд цахим шуудангаар дамжуулах үүрэгтэй.

Статистикийн мэдээллээс үзвэл тухайн жилд тогтвортой ажиллаж байгаа шашны байгууллагуудын тоо хэмжээ хуулийн этгээдээр бүрт шашны байгууллагуудын нийт тооноос бага байгаа нь харагдаж байна.

**Зураг 6. Тогтвортой үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагууд**



Зургаас тухайн жилд тогтвортой үйл ажиллагаа явуулж буй христийн шашны байгууллагууд тогтмол өсч, харин буддын шашны байгууллагуудын тоо аажмаар буурч байгаа нь харагдаж байна. Үүнд, санхүүгийн нөөц бололцоо, байгууллагын менежментийн болон хүний нөөцийг хөгжил, шашны байгууллага хоорондын хамтын ажиллагаа, сүсэгтний дэмжлэг, оролцоо зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байгаа нь дамжиггүй. Цаашид энэ чиглэлээр нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай.


Шашны олон нийтийн байгууллагууд манай улсад багагүй хэмжээтэй байна. Судалгаанд хамрагдсан 8200 гаруй төрийн бус байгууллагын<sup>1</sup> 2.3 орчим хувь (194) нь шашны олон нийтийн байгууллага юм<sup>2</sup>.

<sup>1</sup> 2017 оны 3-р сарын байдлаар, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, эх сурвалж: www.1212.mn

<sup>2</sup> Бид Хуулийн этгээдийн улсын бүртгэлд төрийн бус байгууллагаар бүртгэгдсэн 8000 гаруй байгууллагаас байгууллагын нэр, үйл ажиллагааны үндсэн чиглэлээр шууд шашинд хамаарах байгууллагууд, христийн шашны тулаас үйлчилгээний байгууллагуудыг энд багтаан авч үзсэн.

Эдгээр байгууллагын дотор христийн шашны байгууллагууд ч мөн адил давамгайлах хандлагатай байгаа бөгөөд 33%-ийг эзэлж байна. Харин 27% нь буддын шашны олон нийтийн байгууллагууд, 25% нь бөөгийн шашны олон нийтийн байгууллагууд ажээ.


**Зураг 7. Шашны олон нийтийн байгууллагууд, шашны урсгал чиглэлээр**



Шашны олон нийтийн байгууллага нь сүм хийд тэргүүтэй шашны байгууллагын уламжлалт хэлбэрийн байгууллагуудаас онцлох ялгаатайг өмнө нь дурдсан. Энэ чиглэлээр ч миний бие хэд хэдэн удаагийн өгүүлэл, илтгэлд тодорхой өгүүлсэн тул энд нуршсангүй.

Шашны олон нийтийн байгууллагыг манай нөхцөлд шашны байгууллага гэж үзэхгүй байгаа нь нэг талаас олон нийтийн дунд төөрөгдөл үүсэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна гэж үзэх үндэс бий. Эдгээр байгууллага нь шашны хурал ном, мөргөл, зан үйлийг чухалчилаад байдаггүй ч шашны үзэл санаа, соёл уламжлалыг нийгэд түгээж, сурталчилахад чухал үүрэг гүйцэтгэдгийг дараах зургаас харж болно.


**Зураг 8. Шашны олон нийтийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл**



Өнөөдөр Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газраас Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөл авсан олон улсын 100 шахам байгууллага байгаагийн 9 нь байгууллагын нэр, үүсгэн байгуулагч, олон улсад нээлттэй зарласан үйл ажиллагааны зарчим зэргээр нь сурвалжлан үзвэл шашинтай ямар нэгэн хэлбэрээр холбоотой байна<sup>1</sup>.

Хэдийгээр эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг шууд утгаар нь шашинтай холбон үзэж болохгүй боловч үйл ажиллагааны онцлог, санхүүжилтийн эх үүсвэр, байгууллагын үзэл санааны эх сурвалж нь шашинтай их, бага хэмжээгээр холбоотой, зарим тохиолдолд Монгол Улс дахь зарим үйл ажиллагаа нь шашны байгууллагаар дамжин эсвэл хамтран хэрэгждэг нь ингэж үзэхэд хүргэж байгаа юм.

**Зураг 9. Шашинтай холбоотой олон улсын байгууллагууд, үйл ажиллагааны төрлөөр, 2018**




### Шашны байгууллагын тархалт

Монгол Улсад бидний бүртгэж тогтоосон 812 шашны байгууллагын 58.2% буюу 477 нь орон нутагт, 41.2% буюу 335 нь Улаанбаатар хотод оршиж байна. Эдгээрээс буддын шашны сүм хийд, христийн шашны байгууллагууд орон нутагт бараг ижил хэмжээтэй (буддын шашин 217 – христийн шашин 211) түлхүү оршиж байгаа бол, Улаанбаатар хотод христийн шашны байгууллагууд илүү төвлөрсөн байдалтай байна (буддын шашин 90 – христийн шашин 225). Нийт орон нутагт тархсан байдлыг авч үзвэл дараах байдалтай байна.

<sup>1</sup> Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын бүртгэл (2019 он) Гадаадын иргэн, харьяатын газрын цахим хуудас: <https://immigration.gov.mn/index.php/blog/post/mongol-ulsad-jl-azhillagaa-yavuulzh-buj-olon-ulsyn-bolon-gadaad-ulsyn-trijn-bus-bajguullaga-salbar-tllgchijn-gazruud>

**Зураг 10. Орон нутаг дахь шашны байгууллагууд**



Шашны байгууллагын хамгийн өргөн тархсан буюу 30-аас дээш сүм хийд, шашны байгууллагатай нутгуудад Архангай, Дархан-Уул, Завхан, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймгууд орж байна.


Буддын шашны сүм хийд Говь-Алтай, Завхан, Сүхбаатар аймагт давамгайл байдлаар оршиж байгаа бол Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Өмнөговь, Төв аймагт христийн шашны байгууллагууд түлхүү ажиллаж байна.

Эндээс харахад цөөн хүн амтай газар нутагт буддын шашны сүм хийдүүд, байгаа бол хүн ам нягт суурьшсан хот суурин газруудад христийн шашны байгууллагууд зонхилж байгаа нь харагдана.

Баян-Өлгий аймаг бүхэлдээ, Ховд аймгийн зарим сумд, Дархан-Уул, Увс, Төв, Сэлэнгэ, Орхон аймгуудад цөөн тоогоор исламын шашны мечет, мөргөлийн төвүүд ажиллаж байна.


Улаанбаатар хотын 335 шашны байгууллагын 67.1%-ийг (225) христийн, 26.8%-ийг (90) буддын сүм хийд эзэлж байна.

**Зураг 11. Улаанбаатар хот дахь шашны байгууллагууд**



Шашны байгууллагын тархалтыг дүүргээр нь харуулбал дараах байдалтай байна.

Зураг 12. Улаанбаатар хот дахь шашны байгууллагууд (дүүргээр)



Зургаас харвал, Баянгол дүүрэгт л буддын шашны хамгийн олон сүм хийд төвлөрч байгаа бөгөөд христийн шашны байгууллагууд ч багагүй хэмжээтэй байна. Мөн Баянголоос бусад бүх дүүрэгт христийн шашны байгууллага зонхилж байгаа юм. Тэр дундаа Баянзүрх дүүрэгт Улаанбаатарын нийт христийн шашны байгууллагын 39% оршиж, уг дүүргийн нийт шашны байгууллагын 83%-ийг христийн шашны байгууллага дангаараа эзэлж байна. Исламын шашны мечет, мөргөлийн газрууд Налайх (3), Баянгол (1), Сонгинохайрхан (1) дүүргүүдэд цөөн тоогоор ажиллаж байна.

Эцэст нь дүгнэхэд шашны байгууллагууд дан ганц уламжлалт хэлбэрүүдээр үл хязгаарлагдах болсон нь өнөөгийн Монгол Улс дахь шашин шүтлэгийн төлөв байдлын нэг онцлог бөгөөд үүнээс үүдэн шашны байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй өнөөгийн эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн сайжруулах зайлшгүй шаардлага бий болсоныг харуулж байна.

Өнөөгийн хууль тогтоомж дахь холбогдох заалтуудад шашны байгууллага гэдэгт зөвхөн сүм хийд, дацан, хурал, төв гэсэн хэлбэрийг багтааж явцуу тодорхойлохын зэрэгцээ шашны байгууллагын үйл ажиллагааны хүрээг шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлаар хязгаарлаж байгаа нь цуглаан, чуулган хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг христийн шашны байгууллагууд, культ, сект зэрэг зарим шашны урсгал, чиглэлүүд, буяны болон нийгмийн зарим нэг үйл ажиллагааны зэрэгцээ шашны үйл ажиллагаа явуулдаг шашны олон нийтийн байгууллага зэрэг шашны бусад хэлбэрийн байгууллагууд хуулийн гадна орхигдоход хүргэж байна.

Цөөнгүй шашны байгууллага зөвшөөрөл, бүртгэлгүй үйл ажиллагаа явуулж байгаа нь эдгээр байгууллагад хүлээлгэх хариуцлагын тухай асуудал орхигдсонтой холбоотой гэж үзэж болохоор байна. Төр сүм хийдийн харилцааны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль зэрэг хууль тогтоомжийн алинд нь ч зөвшөөрөлгүй ажиллаж байгаа шашны байгууллагад хүлээлгэх хариуцлагын тухай заалт байхгүй.

Цаашид холбогдох хууль тогтоомжид зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа шашны байгууллагуудад хариуцлага тооцох механизм бий болгох, шашны байгууллагад зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд мөрддөг нийтлэг журмыг боловсронгуй болгох,

бүртгэлийн холбогдох байгууллага болон шашин судлаачдын хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай.

### НОМ ЗҮЙ

1. Алтайбаатар, Ж. Монгол Улс дахь шинэ шашны хөдөлгөөн: өнөөгийн байдал, хандлага. Улаанбаатар, 2019
2. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын бүртгэл. Гадаадын иргэн, харьяатын газрын цахим хуудас: <https://immigration.gov.mn/index.php/blog/post/mongol-ulsad-jl-azhillagaa-yavuulzh-buj-olon-ulsyn-bolon-gadaad-ulsyn-trijn-bus-bajguullaga-salbar-tllgchijn-gazruud>
3. Смейлзер, Н. Социологи. Улаанбаатар, 2001
4. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, ҮСХ-ний цахим хуудас: [www.1212.mn](http://www.1212.mn)
5. ШУАФХ. Монгол Улс дахь шашин шүтлэгийн төлөв байдлын судалгаа. Улаанбаатар: ШУА-ийн Философийн хүрээлэн, 2017
6. Johnstone, R. Religion in Society: A Sociology of Religion. New Jersey, 2006
7. Martens, K. Mission Impossible? Defining Nongovernmental Organizations. *Voluntas* 13 (4). 2002

### ABSTRACT

A number of surveys on the religious situation of Mongolia have been conducted since the 1990s, but there is insufficient information on the characteristics, types, distribution, and density of religious organizations.

It depends on the activities of government agencies with different functions, but on the other hand, it depends on the sustainability of religious institutions.

This paper aims to clarify the type, form, and distribution of religious organizations in Mongolia by analyzing statistical and registration information on religious organizations.